



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/561

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ойжуулалт, ойн арга хэмжээг хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Отгонжаргал (Байгаль орчны газрын Ойн нэгжийн дарга)

Б.Очирбат (Байгаль орчны газрын ой хариуцсан мэргэжилтэн)

Холбогдох сумдыг хариуцсан Сум дундын Ойн ангийн дарга

Холбогдох сумын Засаг даргын орлогч

Холбогдох сумын багийн Засаг дарга нар

Сумын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч нар

Сумын Байгаль хамгаалагч нар

Нарийн бичгийн дарга: Сум дундын ойн ангийн инженер, техникч

2. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг зохих хууль, журмын дагуу хүлээн авч, улсын комисст хүлээлгэн өгч ажиллахыг ажлын хэсэг (Г.Гантулга)-т даалгасугай.

3. Аймаг, сумын комиссын хүлээж авсан ойжуулалт, нөхөн сэргээлтийн талбайд мал бэлчээхгүй, өвөлжөө, хаваржааны газар олгож хадлан хадуулахгүй байх, ургалтын явцад хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6325010772

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/691 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

